



Мөнгөн ус нь ихэвчлэн алтны хүдрээс алт ялган авахад ашиглагддаг. Энэ явцад бичил уурхайчид мөнгөн устай шууд харьцдаг. Элемент мөнгөн ус нь үнэргүй, өрөөний температурт ууршдаг цорын ганц хүнд металл юм. Уур нь хувцас, багаж хэрэгсэл, хана зэрэг гадаргууд наалдаж тогтдог.

Алт-мөнгөн усны амальгамыг шатаах явцад агаарт ууршсан мөнгөн усаар амьсгалах нь мөнгөн усанд өртөх хамгийн аюултай алхам юм. Мөнгөн усны 80 орчим хувь нь уушгиар дамжин хүний биед шингэх ба цусны эргэлтэд нэвтрэх ялангуяа тархи, бөөрийг гэмтээдэг.

Байгальд хаягдсан мөнгөн ус метилжиж загасанд хуримтлагддаг. Хэрэв хүмүүс хордсон загас идвэл метил мөнгөн усны 95 орчим хувь нь ходоодонд боловсорч, цусанд шингэх ба улмаар хүний тархи, зүрхэнд голчлон нөлөөлдөг.

